

"Си И Си инвестмент ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ нь 2024 онд 2 удаагийн ээлжит биет хурлыг компанийн байр болох Хан-уул дүүргийн 18-р хороо, Моннис бьюлдинг 3 давхарт хийсэн болно.

ТУЗ нь нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 1 хараат бус гишүүнтэй болно.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

1. ТУЗ-ийн дарга Х.Гиймаа
2. ТУЗ-ийн гишүүн Э.Ундрах
3. ТУЗ-ийн гишүүн С.Мягмардорж
4. ТУЗ-ийн гишүүн Ц.Ууганбаяр
5. ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Ундрах-Эрдэнэ
6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Батцэцэг

№	Он сар, өдөр	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр	Ирц
1	2024.02.28	1. 2023 оны Компанийн гүйцэтгэлийн тайлан 2. Зах зээл болон салбарын судалгаа 3. 2024 оны зорилго, зорилт, санхүүгийн төлөвлөгөө	1. Компанийн 2024 оны бүтэц, цалингийн сүлжээ, орлого зарлага, OGSM-ыг батлахаар шийдвэрлэв. 2. Группын урамшууллын системийг банк бусын урамшууллын системтэй уялдуулж чиглэл тус бүрээр ямар ямар шаардлага хангасан байх, шалгуур үзүүлэлтийг гаргаж дараагийн хуралд танилцуулахаар шийдвэрлэв.	100%
2	2024.10.21	1.Компанийн 3-р улирлын үйл ажиллагааны тайлан, цаашид хийх ажлын төлөвлөгөө 2.Зээлийн бодлогын шинэчлэлтийн танилцуулга 3.ТУЗ, Зээлийн хороо, Зээлийн дэд хорооны шийдвэр гаргалтын түвшинд оруулах өөрчлөлтийн санал танилцуулах 4.Шинээр шугамын зээлийн бүтээгдэхүүний танилцуулга	1. Хугацаа хэтэрсэн, чанаргүй, эргэлзээтэй, муу зээлүүдийн талаар ТУЗ-д тайлан бэлтгэн танилцуулж байхаар шийдвэрлэв. 2. Зээл олгох шийдвэр гаргалтын эрх мэдлийн хэмжээнд өөрчлөлт оруулж, зээлийн дэд хороог гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар шийдвэрлэв. 3. ТУЗ хурлыг улирал бүр хийж байх, гишүүдийг мэдээллээр хангаж ажиллаж байх.	100%

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах ажлыг зохион байгуулж ажилдаг. Үүнд:

1. ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, гишүүдэд мэдээлэл хүргэх
2. ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах
3. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлын зохион байгуулах
5. ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах